

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2019 оны жилийн эцсийн байдлаар /

2020.01.03

Дархан-Уул

## **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хяналтанд авсан зүйл, заалттай харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино.

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий Сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, ЗГХЭГ-ын даргын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэнд байршсан 63 шийдвэрийн 99 заалт, Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэгдэж ирсэн тайланг уншиж танилцан, монгол хэл бичгийн болон найруулгын 26 үл тохиролд залруулах арга хэмжээг авч, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу сайжруулалтыг хийж гүйцэтгэв.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалтын дагуу 5 шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.


## **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- ✓ Монгол Улсын 1 хуулийн 1 заалт,
- ✓ УИХ-ын 1 тогтоолын 1 заалт,
- ✓ УИХ-ын байнгын хорооны 2 тогтоолын 3 заалт,
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт,
- ✓ Засгийн газрын 40 тогтоолын 60 заалт,
- ✓ Ерөнхий Сайдын 1 захирамжийн 4 заалт,
- ✓ Засгийн газрын хуралдааны 12 тэмдэглэлийн 16 заалт,
- ✓ Засгийн газрын 3 албан даалгаврын 8 заалт,
- ✓ ЗГХЭГ-ын 2 тушаалын 4 заалт, нийт 63 шийдвэрийн 99 заалтыг хяналтанд аван хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

2017, 2018 оны жилийн эцсийн байдалтай харьцуулахад хяналтад авсан шийдвэр, заалтын тоог харьцуулж диаграммаар харуулбал:

### Дархан-Уул аймгийн хэмжээнд хяналтад авсан шийдвэр, заалтын тоо



Хугацаа	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ
2017 он	76	107	98.30%
2018 он	84	149	98.0%
2019 он	63	99	94.27%
<b>Дундаж</b>	<b>74.3</b>	<b>118.3</b>	<b>96.85%</b>
<b>(Зөрүү -,+)</b>	<b>-21</b>	<b>-50</b>	<b>-</b>

#### Гурав. Үнэлгээний дүгнэлт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2019 оны жилийн эцсийн байдлаар **94.27** хувийн хэрэгжилттэй **4.71** онооны үнэлгээтэй байна.

#### Холбогдох шийдвэрийн төрөл тус бүрээр харуулбал:

№	Биелэлт	Нийт	Шийдвэрийн төрөл									
			МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайддын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЭГХЭЭГ-ын даргын тушаал
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	63	1	1	2	1	-	40	1	12	3	2
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	99	1	1	3	2	-	60	4	16	8	4
3.	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	80	-	1	3	2	-	47	4	13	6	4
	Хэрэгжих шатанд 70% (50-89%)	15	1	-	-	-	-	10	-	2	2	-
	Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	1	-	-	-	-	-	1	-	-	-	-
Хугацаа болоогүй/ Үнэлэх боломжгүй		3	-	-	-	-	-	2	-	1	-	-
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		<b>94.27% буюу 4.71 оноо</b>	70.0 буюу 3.5 оноо	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо	-	93.1% буюу 4.65 оноо	100% буюу 5.0 оноо	96.0% буюу 4.8 оноо	92.5% буюу 4.62 оноо	100% буюу 5.0 оноо

2019 онд хяналтад авсан шийдвэрийн төрлийг 2017, 2018 онуудын хяналтад авсан шийдвэрийн төрөл, заалтын тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Он	Заалтын тоо	Нийт шийдвэрийн төрөл, үүнээс									
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайддын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ын даргын тушаал
2017	107	0	0	3	4	3	58	0	27	12	0
2018	149	2	3	3	7	3	74	5	24	13	15
<b>2019</b>	<b>99</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>60</b>	<b>4</b>	<b>16</b>	<b>8</b>	<b>4</b>
<b>Дундаж</b>	<b>118.3</b>	<b>1</b>	<b>1.3</b>	<b>3</b>	<b>4.3</b>	<b>2</b>	<b>64</b>	<b>3</b>	<b>22.3</b>	<b>11</b>	<b>6.3</b>
Зөрүү / сүүлийн 2 оны хувьд / их, бага /	-50	-1	-2	0	-5	-3	-14	-1	-8	-5	-11

Нэг жилд дунджаар 118 заалтыг хяналтад авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж ажиллалаа. 2019 онд хяналтад авсан заалтын тоо сүүлийн 3 жилийн дунджаас 19 заалтаар бага байгаа нь Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг ханган ажилласныг харуулж байна.

Графикаар харуулбал:



### Холбогдох зохицуулалтын салбараар нь харуулбал:

№	Биелэлт	Нийт	Зохицуулалтын салбар										
			Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал	Төлөвлөлт, санхүү хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр	Батлан хамгаалах, гамшгаас урьд, сэргийлэх	Барилга хот байгуулалт	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт	Зам тээврийн хөгжил	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	63	16	10	2	1	13	3	3	5	4	4	2
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	99	30	15	2	1	18	6	8	8	4	4	3
3.	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	80	23	14	1	1	12	6	7	7	2	4	3
	Хэрэгжих шатанд 70% (50-89%)	15	7	1	-	-	4	-	1	1	1	-	-
	Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	1	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй/ үнэлэх боломжгүй		3	-	-	-	-	2	-	-	-	1	-	-
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		<b>94.27%</b> буюу <b>4.71</b> оноо	93.0% буюу 4.65 оноо	98.0% буюу 4.90 оноо	50.0% буюу 2.50 оноо	100% буюу 5.00 оноо	92.5% буюу 4.62 оноо	100% буюу 5.00 оноо	96.25% буюу 4.81 оноо	96.25% буюу 4.81 оноо	90% буюу 4.50 оноо	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо


2019 онд хяналтад авсан заалтын тоог зохицуулалтын салбараар нь 2017, 2018 онуудын заалтын тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Он / заалтын тоо	Зохицуулалтын салбараар, үүнээс												
	Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал	Төлөвлөлт, санхүү хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр	Батлан хамгаалах, гамшгаас урьд, Сэргийлэх	Барилга хот байгуулалт	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт	Зам тээвэр хөгжил	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд	Уул уурхай	Эрчим хүч
2017 он	25	17	10	6	15	2	7	4	4	5	10	0	1
2018 он	44	18	7	24	18	9	9	5	3	5	6	1	0
<b>2019 он</b>	<b>30</b>	<b>15</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>18</b>	<b>6</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Дундаж</b>	<b>33</b>	<b>16.6</b>	<b>6.3</b>	<b>10.3</b>	<b>17</b>	<b>8.5</b>	<b>8</b>	<b>5.6</b>	<b>3.6</b>	<b>4.6</b>	<b>6.3</b>	<b>0.3</b>	<b>0.3</b>
2018, 2019 оны зөрүү / их,бага/	-14	-3	-5	-23	0	-3	-1	+3	+1	-1	-3	-1	0

Хүснэгтээс харахад сүүлийн 3 жилийн хугацаанд Байгаль орчин аялал жуулчлал, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр, Барилга хот байгуулалт, Боловсрол соёл шинжлэх ухаан, спорт, Зам тээвэр хөгжил, Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Уул уурхай, Эрчим хүчний салбарын хувьд хяналтад авсан заалтын тоо нь харьцангуй тогтмол байсан бол Ерөнхий чиг үүрэг, Төлөвлөлт санхүү хөрөнгө оруулалт, Хууль эрх зүй, Батлан хамгаалах гамшгаас урьдчилан сэргийлэх, Эрүүл мэндийн салбарын хувьд хяналтад авсан заалтын тоо нь 2019 онд багассан нь эдгээр салбаруудын үйл ажиллагааны чиглэлээр 2018 онд гарсан шийдвэрүүдийн хэрэгжилт сайжирснаар 2019 онд үр дүнд хүрч тогтворжсныг харуулж байна.

Графикаар харуулбал:

### Хяналтад авсан заалтын тоо (салбараар)



### Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

#### Сайн тал:

1. Аймгийн Засаг даргын баталсан “Зөвлөмж”-үүдийн хэрэгжилт сайжирсан, тухайлбал:

- ✓ Хяналтнаас хасах саналаа ирүүлсэн,
- ✓ Үг үсэг, найруулгын алдаа эрс багассан,
- ✓ 2000 тэмдэгтэд багтаан, хүрэх түвшинтэй нь уялдуулан үр дүнг тайлагнасан зэрэг сайн талууд байлаа.

#### Анхаарах асуудал:

1. Аймгийн Засаг даргын баталсан ХШҮДАХ-ээс гаргасан “Зөвлөмж”<sup>1</sup>, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын баталсан “Зөвлөмж”-ийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт”<sup>2</sup>-ийг үйл ажиллагаандаа мөрдөж хэвшихийг зөвлөж байна.

<sup>1</sup> Дархан-Уул аймгийн Засаг даргын 2018.07.05-ны өдөр баталсан “Зөвлөмж”,

<sup>2</sup> Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн даргын 2018.09.04-ны өдөр баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын баталсан “Зөвлөмж”-ийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт

**Тав. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтнаас хасаж, орон нутгийн хяналтад авахаар хүргүүлж буй санал:**

Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас нийт 18 шийдвэрийн 21 заалтыг хяналтаас хасуулах тухай саналыг тайлбарын хамт цахим санд тэмдэглэж, орууллаа.

Хяналтнаас хасуулах саналын тоог 2017, 2018 оны саналын тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хасах санал	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
2017 он	12	15
2018 он	25	34
<b>2019 он</b>	<b>18</b>	<b>21</b>
<b>Дундаж</b>	<b>18.3</b>	<b>23.3</b>

Диараммаар харуулбал:

**Цахим сангийн хяналтнаас хасуулах шийдвэр, заалтын тоо**



Дэлгэрэнгүйгээр үзүүлбэл:

Д/Д	ШИЙДВЭР	ЗААЛТ	ТАЙЛБАР
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 1. ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ</b>			
1.	2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018-01-31 Дугаар 2018_32 тогтоол	2.5 “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж үр дүнг тайлагнасан, хугацаа дууссан тул хяналтаас хасах.
2.	2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай	3. Хавсралтаар төлөвлөгөөг оруулав.. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ,	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, 2019 оныг “Хариуцлагын жил”

	2019-01-16 Дугаар 2019_23 тогтоол	харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич: Хавсралтаар оруулсан "ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана.	болгон зарласантай холбогдуулан төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж үр дүнг тайлагнасан, хугацаа дууссан тул хяналтаас хасах.
3.	<b>Дүрэм</b> батлах тухай /Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм/ 2019-01-23 Дугаар 2019_33 тогтоол	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 "Дүгнэлт, зөвлөмжийн тухай" албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
4.	2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 дугаар тэмдэглэл 2019-01-16 Дугаар 2019_3	1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар <b>2019 оны I улиралд багтаан</b> олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах;	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, 1 удаагийн буюу цаг үеийн шинжтэй, тухайн жилдээ хэрэгжилтийг тооцуулсан тул хяналтнаас хасах
5.	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 Дугаар 2017_01 албан даалгавар	2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах.	Засгийн газрын 2019 оны 37, 38 дугаар тогтоол, 15 дугаар тэмдэглэл, Хэрэгжилтийг тухайн жилдээ тооцуулсан, үйл ажиллагаа тогтмолжсон тул хяналтнаас хасуулах
<b>5 шийдвэрийн 5 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 2 БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ</b>			
6.	<b>Хөтөлбөр</b> батлах тухай /Агаар орчны бохирдлыг бууруулах/ 2017-03-20 Дугаар 2017_98	3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо"-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 "Дүгнэлт, зөвлөмжийн тухай" албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
7.	<b>Журам</b> батлах тухай 2017-05-24 Дугаар 2017_151	4. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Б.Баатарцогт нарт, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 "Дүгнэлт, зөвлөмжийн тухай" албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
8.	<b>Хөтөлбөр</b> батлах тухай /Тогтвортой хөгжлийн боловсрол/ 2018-07-04 Дугаар 2018_209	3. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 "Дүгнэлт, зөвлөмжийн тухай" албан бичгийн хэрэгжилтийг

		ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
9.	<b>Үндэсний хөтөлбөр</b> батлах тухай Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах 2019-08-14 Дугаар 2019_318	2.Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэн хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
<b>4 шийдвэрийн 4 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 3. ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>			
10.	<b>Журам</b> батлах тухай Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах 2019-08-07 Дугаар 2019_312	2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу улс, нийслэл, орон нутгийн авто замын санд төвлөрүүлэх, хөрөнгийг холбогдох төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, авто замын сангийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд тус тус үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
<b>1 шийдвэрийн 1 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 5. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭР</b>			
11.	Жагсаалт, <b>журам</b> батлах тухай 2018-08-22 Дугаар 2018_266	2. Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалтад багтсан гоц халдварт, халдварт өвчин оношлогдсон тохиолдолд энэ тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмын дагуу шаардагдах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хяналт тавьж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Мал эмнэлгийн ерөнхий газар, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
12.	Малын гоц халдварт өвчингүй, хорио цээрийн тусгаарлагдсан бүс байгуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2017-09-27 Дугаар 2017_284	1. Малын гоц халдварт өвчингүй эрүүл бүсээс бэлтгэсэн урьдчилан сэргийлэх вакцин таригдаагүй малыг бэлтгэж мах экспортлох зорилгоор хорио цээрийн тусгаарлах бүс байгуулах бэлчээрийн болон хадлан хадах газрыг хуульд заасны дагуу олгож, уг бүсэд хөрөнгө оруулах дотоод, гадаадын аж ахуйн нэгжийн санал, санаачилгыг дэмжин ажиллахыг Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Завхан, Төв, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	ДМАЭМБ-ын зөвлөх, Австралийн Мал эмнэлгийн мэргэжилтэн Андрей МкФадден зөвлөх үйлчилгээ үзүүлж, <b>Дархан-Уул аймгийн хэмжээнд бэлчээрийн даац, хүрэлцээ хангалтгүй байгаад үндэслэн бүсийг Төв, Сэлэнгэ аймгийн нутагт дэд бүтэц бүхий нутгийг сонгохыг зөвлөсөн.</b>
13.		2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу олгосон газар нутгийг түшиглэн хорио цээрийн тусгаарлагдсан бүс байгуулж, хууль тогтоомжийн дагуу дотоод хорио цээрийн дэглэм тогтоон малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын үүрэг гүйцэтгэгч П.Сэргэлэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, холбогдох аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	



14.	2019 оныг “Эх оронч худалдан авалтын жил” болгох тухай 2019-01-30 Дугаар 2019_59	3.. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах, цаг үеийн шинжтэй тул дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
15.		4.. “Эх оронч худалдан авалтын жил”-ийн хүрээнд дотоодод үйлдвэрлэсэн үндэсний бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэхийг нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалсугай.	
<b>3 шийдвэрийн 5 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 7. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ</b>			
16.	Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018-07-09 Дугаар 2018_220	4. Аймаг, нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын ус хангамж, ариутгах татуургын системд их болон урсгал засвар хийх, туршилт тохируулгын ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. 5. Аймгийн төв болон бусад суурин газруудын дулааны станц, халаалтын зуухны тоног төхөөрөмж, шугам сүлжээний засвар үйлчилгээ, нүүрсний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг <b>2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор</b> хэрэгжүүлж дуусгахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, 1 удаагийн буюу цаг үеийн шинжтэй, тухайн жилдээ хэрэгжилтийг тооцуулсан тул хяналтнаас хасах
<b>1 шийдвэрийн 2 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 8. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТ</b>			
17.	Олон улсын хүүхдийн спортын наадам зохион байгуулах тухай 2016-11-16 Дугаар 2016_145	3 “Азийн хүүхдүүд” олон улсын хүүхдийн спортын YII наадамд Монгол Улсыг төлөөлөн оролцох өсвөрийн тамирчдыг үе шаттай бэлтгэж, дэмжлэг үзүүлэх зорилгоор Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг олон улсын хүүхдийн спортын YII наадмын хөтөлбөрт орсон спортын төрлүүдээр байгуулан хүүхэд, залуучуудын дунд тэмцээн, уралдаан зохион байгуулж, өсвөрийн тамирчдын амжилтыг урамшуулахад шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусган ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, цаг үеийн шинжтэй буюу 2019 онд зохион байгуулсагдсан, тухайн жилдээ хэрэгжилтийг бүрэн хангасан үр дүнг тооцуулсан тул хяналтнаас хасах
18.	<b>Үндэсний хөтөлбөр</b> батлах тухай Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2019-08-21 Дугаар 2019_335	3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
19.	Өндөрлөг байршилд спортын бэлтгэлийн төв байгуулах тухай 2014-01-11 Дугаар 05_2014_02	2 Спортын бэлтгэлийн төв байгуулах тохиромжтой байршлуудыг орон нутгийн хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд тусган газар олгож, дэмжин ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, хэрэгжилтийг бүрэн хангасан үр дүнг тооцуулсан тул хяналтнаас хасах
<b>3 шийдвэрийн 3 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 10. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ</b>			

20.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-03-26 Дугаар 2016_09/03 УИХ-ын БХТогтоол	1.5/ Бүх шатны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах асуудлыг Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусгаж, үүрэгжүүлж ажиллуулах	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах, үйл ажиллагаа тогтмолжсон
<b>1 шийдвэрийн 1 заалт</b>			
<b>НИЙТ 18 ШИЙДВЭРИЙН 21 ЗААЛТ</b>			

ТАНИЛЦСАН:  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ОРЛОГЧ Т.ГАНБОЛД

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН